

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН “НЭЭЛТТЭЙ МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ” ТАЙЛАНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

2025.02.01

ТАНИЛЦУУЛГА

Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хамаарах 26 төрлийн мэдээллийг ил тод, нээлттэй болгон Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор баталсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоон, үнэлгээ хийх журам”-ын 3 дахь заалтыг хэрэгжүүлэн ажиллажээ.

Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолоор батлагдсан “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, хяналт тавих нийтлэг журам”-ын дагуу чиг үүрэгт хамаарах мэдээллийг агуулсан мэдээллийн сан үүсгэж “Төрийн байгууллагын вэбсайтад тавих шаардлага” MNS 6285:2017” стандартыг ханган өөрийн цахим хуудас болох cabinet.gov.mn – Монгол Улсын Засгийн газрын Хэрэг Эрхлэх Газар хаяг бүхий сайтад холбогдох мэдээ, мэдээллийг байршуулсан байна.

Цахим хуудас дахь мэдээллийн агуулгыг бүлэглэх, цэс үүсгэх, хайлтын системд хайлт хийх зэрэг нөхцөлийг бүрдүүлжээ.

Нийтийн
мэдээллийн ил тод
байдлын тухай
хууль



8.2.1

Чиг, үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийг ил тод, нээлттэй байлгах хүрээнд Засгийн газрын 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 05 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын бүтэц, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, газар, нэгжийн чиг үүрэг, албан хаагчдын мэдээллийг шинэчлэн нийтэлсэн.



8.3.2, 8.3.3, 8.3.6

Хүний нөөцийн талаарх мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгах хүрээнд 2024 онд 2 удаа ажлын байрны сул орон тооны талаарх мэдээллийг өөрийн цахим хуудсанд нийтэлсэн түүнээс гадна Төрийн албаны зөвлөлийн www.csc.gov.mn цахим хуудсанд байршуулсан.



8.4.1, 8.4.2, 8.4.3, 8.4.4, 8.4.5

Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийг нийтлэх хүрээнд мэдээллийг www.shilendans.gov.mn -д тухай бүр нийтэлсэн.



8.6.1

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хууль, Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг цахим хуудсандаа байршуулан санал авсан. Мөн хүчин төгөлдөр болсон хууль тогтоомжийг www.legalinfo.mn цахим хуудсанд шуурхай байршуулан ажилласан.



8.6

Авлигын эсрэг хууль тогтоомж, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, холбогдох мэдээ, мэдээлэл, танилцуулга, маягт зэргийг нийтэлсэн.



Байгууллагын цахим хуудасны мэдээ, мэдээлэл буланд цаг үеийн болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 120 гаруй мэдээллийг байршуулж, иргэд олон нийтэд хүргэсэн.



Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвийн www.11-11.mn цахим хуудсыг тогтмол ажиллуулан ил тод нээлттэй байдлыг ханган иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийн 7 хоногийн шийдвэрлэлтийн мэдээ мэдээллийг нийтэлж, мөн Засгийн газрын хуралдаанд танилцуулж ажилласан.



Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хамааралтай Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээний талаарх үзүүлэлт.

Хавсралт-1

Хэсэг 1

код	д/д	Нээлттэй мэдээлэл	Шалгуур үзүүлэлтийн оноо				Хувь
			МХБ	ХНБ	МБББ	ЭСТБ	
Нэг.Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал							
1.1	1	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн	20	30	20	30	91.6%
1.2	2	Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг	20	30	30	30	91.6%
1.6	3	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт	30	30	30	30	100%
1.7	4	Албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг	20	30	30	30	91.6%

1.8	5	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ	20	30	30	30	91.6%
1.10	6	Мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр, мэдээлэл	20	30	30	30	91.6%
Дундаж оноо, хувь							93%
Хоёр.Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал							
2.1	7	Ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл	20	30	30	30	91.6%
2.2	8	Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам	20	30	30	30	91.6%
2.3	9	Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм	30	30	30	30	100%
2.4	10	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам	15	30	30	30	87.5%
2.5	11	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ	15	30	30	30	87.5%
2.6	12	Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам	20	30	30	30	91.6%
Дундаж оноо, хувь							91.6%
Гурав. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал							
3.1	13	Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл	30	30	30	30	100%
3.2	14	Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан	30	30	30	30	100%
3.3	15	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт	30	30	30	30	100%
3.5	16	Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар	15	30	30	30	87.5%
3.6	17	Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг	15	30	30	30	87.5%
3.7	18	Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт	15	30	30	30	87.5%
3.9	19	Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл	25	30	30	30	95.8%
3.10	20	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан	15	30	30	30	87.5%
3.11	21	Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт	20	30	30	30	91.6%
Дундаж оноо, хувь							93%
Дөрөв. Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал							
4.2		Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон,	Хамаарах үйлчилгээ байхгүй				

		сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон зөвшөөрлийн талаарх мэдээлэл, зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа.					
Дундаж оноо, хувь							
Тав.Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал							
5.1	22	Олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал	30	30	30	30	100
5.21	23	Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилсан байдал, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан	20	30	30	30	91.6%
5.22	24	Албан тушаалтны Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.1-д заасан ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл болон энэ хуулийн 8.6-д заасан тайлбар	15	30	30	30	87.5%
5.23	25	Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлт	15	20	20	30	70.8%
5.24	26	Төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэл	30	30	30	30	100
Дундаж оноо, хувь							89.9%
Үнэлгээний ерөнхий оноо, хувь							91.8%

ДҮГНЭЛТ

Нийтийн мэдээллийн ил тод байдлын хуульд заасны дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хамаарах 26 төрлийн мэдээллийг ил тод, нээлттэй байлган ажиллаж байгаа эсэхэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд **91.8** хувьтай дүгнэгдэж байна.

Дараах зүйлийг анхаарч ажиллах шаардлагатай гэж үзлээ. Үүнд:

1.Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам, хүний нөөцийн удирдлагын авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг ил тод, нээлттэй болгох, түүнчлэн шилэн дансны талаарх мэдээллээс бусад төсөв, санхүүгийн холбогдолтой мэдээллийг ил тод, нээлттэй болгон нийтлэн ажиллах шаардлагатай гэж дүгнэлээ.

2.Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилсан байдал, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, албан тушаалтны нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.1, 8.6-д заасан мэдээллийг нэгтгэн дүгнэж байх нь хуульд нийцэж байна.

3.Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хүрээнд хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, судалгааны талаар иргэд, байгууллагаас өгсөн саналуудыг нийтэлсэн байдал дутмаг, бусад мэдээллийн бүрэн бүтэн байдлыг ханган нийтэлсэн байдал нь хангалтгүй байна.

ЗӨВЛӨМЖ

1.Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолоор батлагдсан “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, хяналт тавих нийтлэг журам”-ын хэрэгжилтэд Цахим засаглал, мэдээллийн технологийн газар хариуцаж, хяналт тавих;

2.Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор батлагдсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ын 2, 3 дахь заалтыг мөрдлөг болгон хэвших,

2.1.мэдээллийн хүртээмжтэй байдлыг хангах буюу дан ганц цахим хуудас гэхгүй хэвлэл мэдээллийн хэрэгсэл, самбар, тараах материал зэрэг хэлбэрээр нийтлэх /Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.8-д заасны дагуу олон нийтэд ил тод мэдээлэх /;

2.2.хугацаандаа нийтлэх байдал буюу тухайн мэдээллүүдийг хууль бусад журамд заасан хугацаанд нийтлэх /Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.9, 8.11-д заасан хугацаанд олон нийтэд хүргэх/;

2.3.мэдээллийн бүрэн бүтэн байдлыг ханган нийтлэх /Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.2-8.6-д заасны дагуу бүрэн гүйцэд тусгах/;

2.4.нээлттэй мэдээллийг дэлгэрүүлж авах, тодруулах тохиолдолд тус мэдээллийг өгөх эх сурвалжийг цахим хуудсанд тодорхой заах /Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.13-д заасны дагуу бүрэн гүйцэд байршуулах/.

3.“Төрийн байгууллагын веб сайтад тавих шаардлага” Монгол Улсын MNS 6285:2017 стандартыг хангасан, Веб контентын хүртээмжийг нэмэгдүүлэх аргачлал (WCAG 2.1 зөвлөмж)-д нийцсэн байдлаар цахим хуудасны загвар дизайныг сайжруулан, хөгжүүлэх;

4.Засгийн газрын бодлого, шийдвэр, хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр, үйл ажиллагааг мэдээлэх, таниулах чиглэлээр зохих цахим хуудас (www.mongolia.gov.mn, www.gov.mn)-тай холбоосоор холбогдон түгээх, түүнчлэн цахим хуудсанд байршуулах шаардлагатай харьяа байгууллага болон бусад холбогдох хууль тогтоомжид заасан цахим мэдээллийн холбоосыг байршуулах талаар судалж, хэрэгжүүлэх;

5.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль тогтоомжийн хүрээнд холбогдох ил тод, нээлттэй мэдээлэх, нийтлэх мэдээллийг чиг үүргийн дагуу бүтцийн нэгжүүд хариуцан тухай бүр цахим хуудсанд оруулах, мөн тухайн нэгж, албан тушаалтан гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлэх;

6.Хэрэгжилтийн тайланг хагас, бүтэн жилээр гарган Дүн шинжилгээ, дотоод аудитын хэлтэст ирүүлж үнэлгээг хийлгэж байх.

ДҮН ШИНЖИЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС